

БАТЛАВ.

ЧУЛУУНХОРООТ СУМЫН

ЗАСАГ ДАРГА

З.ГЭРЭЛТ-ОД

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Харьцуулалт /

Гэрээний дугаар: Соёлын төв Номын сангийн тоног төхөөрөмж худалдан авах  
0713/ОНХС/2020-13

Чулуунхороот сум  
2020 он

БАТЛАВ.

ЗАСАГ ДАРГА

3.ГЭРЭЛТ-ОД

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2020.01.25

Техникийн тодорхойлолтын хураангуй: “**Соёлын төв Номын сангийн тоног төхөөрөмж худалдан авах**” ажил нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байх шаардлагатай

| Д/д | Тоног төхөөрөмж,<br>эд хэрэглэлийн<br>нэр | Тоо<br>ширхэг | Төлөв<br>байдал | Үзүүлэлт   |
|-----|---|---------------|-----------------|--|
| 1   | Лед дэлгэц                                | 2,5 x 4       | Шинэ            | <p>Загвар P5-тай дүйцэхүйц<br/>Нягтрал 5mm<br/>Лед төрөл SMD2121<br/>Модуль хэмжээ 320x160mm<br/>Модуль нягтрал 64x32 =2048 pixels<br/>Pixel Density 40000 pixels/m<sup>2</sup><br/>Drive Mode 1/16 scan<br/>Гэрэлтүүлэг &gt;800cd/m<sup>2</sup><br/>Refresh Rate ≥960HZ<br/>Gray Scale 12-16 bits<br/>Харагдах өнцөг 140°(H)/140°(V)<br/>Харагдах хэмжээ 5-80M<br/>Ажиллах хүчдэл Input AC 100~240;<br/>Output DC 5V<br/>Дундаж цахилгаан зарцуулалт 400W/<br/>m<sup>2</sup><br/>Цахилгаан зарцуулалт 800W/m<sup>2</sup><br/>Ажиллах хугацаа 100,000 hours<br/>Ажиллах темпратур -20°C-45°C/10%-<br/>90%<br/>Хадгалах Темпратур -40°C-55°C/10%-<br/>90%<br/>Илгээч карт</p> |
| 3   | Төмөр хийц болон<br>угсралт               | 2,5x4         | Шинэ            | Төмөр хийц суурилуулалт бэхэлгээ<br>дэлгэцэндээ тохирсон металъ рам<br>хийцтэй байна.  |

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Чулуунхороот сумын Засаг даргын Тамгын газар** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос **Соёлын төв Номын сангийн тоног төхөөрөмж худалдан авах ажлыг** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендериин баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Цахим тендериин хураамж **50,000** төгрөг.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын талаар дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 1 жил буюу 2019 он

Үнийн саналыг **2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 13 цаг 00 минутаас** өмнө ирүүлэх бөгөөд нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан **2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн өдрийн 13 цаг 30 минутад** нээнэ.

Орон нутгийн давуу эрх эсэх: Тооцохгүй

Сонирхсон этгээд тендериин баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорнод аймгийн Чулуунхороот сумын 1-р баг,  
Чулуунхороот сумын ЗДТГ-ын байрны 1 дүгээр давхар.

Утас: 99192270 88266877 88574725

Цахим шуудан: [info@umch.dd.gov.mn](mailto:info@umch.dd.gov.mn), [tumur.enkhzul@gmail.com](mailto:tumur.enkhzul@gmail.com)

Цахим хуудас: [www.umch.dd.gov.mn](http://www.umch.dd.gov.mn), [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |  |   |
|--|---|
| <p><b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b></p> | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p>  |
| <p><b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b></p>               | <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> <p>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p> |
| <p><b>3. Тендерийн иж бүрдэл</b></p>                           | <p>3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <p>(а) Үнийн санал;</p> <p>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;</p> <p>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;</p> <p>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;</p> <p>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]</p>   |
| <p><b>4. Тогтмол үнэ</b></p>                                   | <p>4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</p>   |
| <p><b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b></p> | <p>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p> <p>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.</p>  |
| <p><b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b></p>           | <p>6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p>   |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

| <b>ТОӨЗ-НЫ-ХОЛБОГОХ ЗААЛТ</b> | <b>А. Ерөнхий зүйл</b>  |
|-------------------------------|---|
| <b>ТОӨЗ 1.1</b>               | Захиалагч нь : Дорнод аймаг Чулуунхороот сумын Засаг даргын Тамгын газар Чулуунхороот сумын Дэлгэр баг  |
| <b>ТОӨЗ 1.1</b>               | Тендер шалгаруулалтын нэр болон дугаар:<br><b>Соёлын төв Номын сангийн тоног төхөөрөмж худалдан авах</b>  |
| <b>ТОӨЗ 2.1</b>               | Санхүүжилтийн эх үүсвэр: Орон нутгийн хөгжлийн сан  |
|                               | <b>Б. Тендерийн баримт бичиг</b>  |
| <b>ТОӨЗ 8.1</b>               | Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулгыг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим сайтаас авна.  |
|                               | <b>В. Тендер бэлтгэх</b>  |
| <b>ТОӨЗ 11.1</b>              | Тендерийн хэл нь зөвхөн Монгол хэл дээр байна.  |
| <b>ТОӨЗ 12.1</b>              | Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд : <ul style="list-style-type: none"> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн Нотариатаар баталгаажуулсан хуулбар</li> <li>- Бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэхээ мэдэгдсэн албан бичиг заавал ирүүлнэ.</li> <li>- Тендерт санал болгосон тоног төхөөрөмжийг ашиглалтанд хүлээлгэн өгсөн акт үйлдсэнээс хойш 12 сараас доошгүй хугацаатай чанарын баталгаатай байх шаардлагатай байх бөгөөд чанарын баталгаа гаргаж буйгаа албан бичгээр мэдэгдэнэ.</li> <li>- Монгол улсын хууль тогтоомжийн дагуу татвараа төлсөн тухай тодорхойлолт /Татварын байгууллагын тодорхойлолт эх хувиар/</li> <li>- Одоогийн ба сүүлийн 2 жилийн хугацаанд тендерт оролцгчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаархи мэдээлэл</li> <li>- Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт,</li> <li>- Шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт,</li> <li>- Харилцагч банкны тодорхойлолт</li> </ul> |
| <b>ТОӨЗ 14.1</b>              | Хувилбар тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.  |
| <b>ТОӨЗ 15.5</b>              | Олон улсын худалдааны Incoterms/инкотермс-ийн хувилбар: "Incoterms 2010"  |
| <b>ТОӨЗ 15.9</b>              | Бараа хүргэгдэх газар: Дорнод Чулуунхороот сум Дэлгэр баг   |
| <b>ТОӨЗ 15.9</b>              | Бараа хүргэгдэх эцсийн цэг: Дорнод Чулуунхороот сум Соёлын төв  |
| <b>ТОӨЗ 15.10</b>             | Тендерт оролцгчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулахгүй тогтмол байна.  |
| <b>ТОӨЗ 16.1</b>              | Тендерийн валют: Төгрөг байна.  |
| <b>ТОӨЗ 18.1</b>              | Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2019 оны жилийн эцсийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.  |
| <b>ТОӨЗ 18.4</b>              | Дотоодын давуу эрхийн зөрүү: Тооцохгүй  |
| <b>ТОӨЗ 20.1</b>              | Тендер нээснээс хойш 45 хоногийн туршид хүчинтэй байна.   |

## БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| Нэр | Тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжийн нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа |                          |                                      |
|-----|--------------|------------|--------------|--|---|--------------------------|--------------------------------------|
|     |              |            |              |  | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа                               | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа |
| 1   | 2            | 3          | 4            | 5                                      | 6   | 7                        | 8                                    |
|     |              |            |              |  | Гэрээ байгуулах эрх олгосноос хойш                            | Хуанлийн 30 хоног        |                                      |
|     |              |            |              |  |   |                          |                                      |
|     |              |            |              |  |   |                          |                                      |

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл          | Тодорхойлолт | Барааны гарал үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1                  | 2            | 3                         | 4          | 5        | 6        | 7                             | 8        |
|                    |              |                           |            |          |          |                               |          |
|                    |              |                           |            |          |          |                               |          |
| Тендерийн нийт үнэ |              |                           |            |          |          |                               |          |

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч,<br>холбоо барих<br>хаяг/утас/фак<br>с | Гэрээний үнийн<br>дүн | Гэрээний эхлэх<br>хугацаа | Гэрээний<br>дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1.           |  |                       |                           |                            |
| 2.           |  |                       |                           |                            |
| 3.           |  |                       |                           |                            |
| 4.           |  |                       |                           |                            |
| 5.           |  |                       |                           |                            |
| бусад.       |  |                       |                           |                            |

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

|   |       |  |
|---|-------|--|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.   |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| <b>9. Алданги оногдуулах</b>                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| <b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| <b>11. Маргааныг шийдвэрлэх</b>                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>   | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b>   | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |  |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн <b>[moο]<sup>1</sup></b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup></b>  | 9.1. Алданги оногдуулах хувь: <b>[moο]</b><br>Алдангийн нийт дүн: <b>[moο]</b>   |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>3</sup>

БАТЛАВ.

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]